



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027
И-мэйл: info@fchm.edu.mn

2024.11.20 № 11822
танай 2024.10.30-ны № 6/4416 -Т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
БОДЛОГЫН ГАЗАРТ**

Тайлан хүргүүлэх тухай

2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 6/4416 тоот албан бичгийн дагуу эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар хүргүүлж байна.

Дараах арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хүргүүлж байна.

1. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө- Эрүүл мэндийн сайдын А/760 дугаар тушаал
2. “Хавдрын эсрэг” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө- Эрүүл мэндийн сайдын А/360 дугаар тушаал
3. “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө- Эрүүл мэндийн сайдын А/186 дугаар тушаал
4. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө- Эрүүл мэндийн сайдын А/559 дугаар тушаал
5. “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө- Эрүүл мэндийн сайдын А/780 дугаар тушаал
6. “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний (2022-2025 он) төлөвлөгөө- Эрүүл мэндийн сайдын А/523 дугаар тушаал
7. “Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний (2024-2027 он) төлөвлөгөө батлах тухай”- Эрүүл мэндийн сайдын А/111 дүгээр тушаал
8. “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээний (2024-2027 он) төлөвлөгөө батлах тухай- Эрүүл мэндийн сайдын А/148 дугаар тушаал
9. “Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын (2024-2026 он) арга хэмжээний төлөвлөгөө”- Эрүүл мэндийн сайдын А/147 дугаар тушаал
10. “Эрүүл мэндийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого, 2021-2024 онд бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”- Эрүүл мэндийн сайдын А/625 дугаар тушаал

Хавсралт 75 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ГҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.БЯМБАСҮРЭН




003096

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

ЭХ,ХҮҮХЭД, НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр /сая төг/		
Зорилго1: Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах						
Зорилт 4. Хүн амын дунд эх, хүүхэд, нөхөн үржихүйн чиглэлээр орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндийн боловсрол олгож, мэдлэг хандлага, дадлыг дээшлүүлэн эрсдэлт, хүчин зүйлийг бууруулах замаар ээлтэй орчин бүрдүүлэх						
1.	4.3. Гэр бүл олон нийтэд чиглэсэн нярай, хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн талаар мэдээллийн бүх хэрэгсэл ашиглан хооллолт, хөдөлгөөн, эрүүл амьдралын зан үйлийн талаар сошиал медиа контентууд боловсруулах	Үр дүнг дүгнэх	-	-	1. Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн сэтгэцийн эмгэг судлаач, сэтгэл заслын их эмч А.Оюунжаргал нь Бидний мэдрэмж ТББ-тай хамтран фэйсбүүкийн “Medic” цахим хуудсыг хөтлөн явуулдаг бөгөөд хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийн талаарх цуврал медиа контентуудыг хамтран хийж цахим орчинд байршуулан түгээн ажиллаж байна. 2024 онд хүүхдэд чиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр “Хүүхэд насны сэтгэл зүйн гэмтэл”, “Сэтгэл гутрал”, “Хүүхэд, өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн өнөөгийн байдал”, “Стрессийн шалтгаант	

таргалалт” сэдвүүдээр 4 удаагийн ярилцлага видео бэлтгэн хүргэсэн байна.



Зураг 1.Мэдээлэл байршуулсан явцаас

2. УНТЭ-ийн хоолзүйч Э.Санчир нь 2024 онд УНТЭ-ийн дотоод шүүрэл диабетын төвийн хяналтанд байдаг чихрийн шижин хэв шинж I-тэй 20 гаруй үйлчлүүлэгч болон тэдгээрийн ар гэрт чихрийн шижин үеийн хооллолт, хүнсний шошгоор илчлэг тооцох аргачлал зэрэг сэдвийн хүрээнд 4 удаагийн танхимын сургалт зохион байгуулсан бөгөөд хамрагдсан үйлчлүүлэгчдэд шаардлагатай тохиолдолд цахимаар тогтмол зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.



Зураг 2. Сургалтын явцаас

3. УНТЭ-ийн Эцэг эхийн зөвлөлөөс 2024.04.16-ны зохион байгуулсан “Аав ээжийнхээ ажлын нэг өдөртэй танилцах” өдөрлөгт оролцсон ЕБС-ын 12-р ангийн 15 сурагчдад “Эрүүл зөв хооллолт, БЖИ тооцох аргачлал, Хоолны илчлэг тооцох арга” зэрэг сэдвийн хүрээнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



Зураг 3.Өдөрлөгийн явцаас

4. 2024/11/10 -нд Дэлхийн чихрийн шижингийн өдрийг тохиолдуулан "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ ажилтнуудад "Чихрийн

шижин ба эрүүл мэнд" сэдвээр өдөрлөг зохион байгуулсан



Зураг 4.Өдөрлөгийн явцаас

5. 2024/09/21-2024/09/22 - нд ЭМЯ болон “Монголын хоолзүйчдийн холбоо” зохион байгуулсан эх хүүхдийн эрүүл мэндэд зориулсан Wellbeing Expo -нд оролцож “Өсвөр насны хооллолт” сэдвээр сургалт явуулсан. Мөн 2 өдөр өдөрлөгт хоол зүйн зөвлөгөө өгч ажилласан.



Зураг 5.Өдөрлөгийн явцаас

					6. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жилтэй холбогдуулан 2024/05/22-нд иргэдэд хоолзүй, сэтгэцийн үзлэг зөвлөгөө хийж ажилласан  Зураг 6.Өдөрлөгийн явцаас	
Зорилт 4 Хүн амын дунд эх, хүүхэд, нөхөн үржихүйн чиглэлээр орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндийн боловсрол олгох мэдлэг, хандалга, дадлыг дээшлүүлэн, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах замаар ээлтэй орчинг бүрдүүлэх						
2.	4.9 Эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжлэгт орчинг бүрдүүлэхэд их дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн удирдлагын багийг оролцуулсан ухуулга нөлөөлийн ажил зохион байгуулах	Олон нийтэд сухтчилсан байна			Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн ЯТТ, УХТ нь анафилаксийн шокийн үед үзүүлэх яаралтай тусламжийн алгоритм бүхий зөвлөгөө мэдээллийн баннерийг эрхлэн гаргасан бөгөөд ЕБС-ийн Наран сургууль, 21-р сургууль, эмнэлгийн амбулаторын хэсгүүдэд байршуулсан.  Зураг 3 . Зөвлөмж	

ЗОРИЛТ 5. Эх, ураг, нярай, хүүхэд, өсвөр үе, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

Үйл ажиллагааны чиглэл 5.1 Эх бариа эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

3.	5.1.2 Эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал, хөх, дотоод шүүрлийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	Хөх дотоод шүүрлийн кабинетуудыг орон нутагт үе шаттайгаар байгуулсан байна.	-	-	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг нь МУЗГ, ЭМЯ-наас санаачлан хэрэгжүүлж буй “Хүн амын нас, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоо”-г ЭМДТ дээр зохион байгуулж СБД-н I-VI хороо, ЧД 17-19 хороотой хамтран 18-с дээш насны хүн амыг эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамруулан ажиллаж байна. 2024 оны 11 сарын байдлаар 1278 иргэнийг эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамруулснаас 59 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Үзлэгт хамрагдсан иргэдийн 40-с дээш насны иргэнийг ЭМС-ын 2023 оны A/379 тоот тушаалын дагуу хөхний хэт авиан үзлэг шинжилгээг хийж ажилласан.Үзлэгийн явцад эмгэг өөрчлөлттэй, нарийн шинжилгээ хийлгэх шаардлагатай иргэдийг дараагийн шатны нарийн мэргэжлийн эмнэлэгт шилжүүлэх, хөхний нарийн мэргэжлийн үзлэгт хамруулан ажиллаж байна. Мөн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд товлолт насны /30,33,36,39,42,45,48,51,54,57,60/ эмэгтэйчүүдэд пап эсийн буюу умайн хүзүүний хорт хавдар болон хавдрын урьдал эмгэгийг эрт илрүүлэх
----	--	---	---	---	---

				шинжилгээг хийж байгаа бөгөөд 2024 оны 11 сарын байдлаар жилд 187 эмэгтэй үйлчлүүлэгчдээс шинжилгээ авснаас 9 иргэнд хавдрын урьдал эмгэг илэрсэн ба дараагийн шатлалд шилжүүлэн онош тодруулахаар илгээн ажилласан байна.  <i>Зураг 4. Үзлэгийн явцаас</i>	
--	--	--	--	--	--

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ
ХАВДРЫН ЭСРЭГ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр /сая төг/		
Зорилго: Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох тогтолцоог бүрдүүлэн иргэдэд хүрэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах						
Зорилт 2: Хүн амын дунд эрүүл мэндийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах						
1.	2.2.2 ДЭМБ-ын “Тамхины эсрэг хувьсгал” хөдөлгөөнийг эрүүл мэндийн байгууллагад өрнүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын дотоод гадаад орчныг тамхигүй орчин болгох	Аяныг тогтмол зохион байгуулж, манлайлсан байгууллага хамт олныг урамшуулж олон нийтэд сурталчилсан байна.	.	-	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн НЭМАлба нь тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эмнэлгийн орчин дахь эрүүл аюулгүй ажлын байр бүрдүүлэх, дам тамхидалтанд өртөхөөс урьдчилан сэргийлэх, ажлын хүрээнд “Эмнэлэг тамхигүй ногоон бүс” ухуулга нөлөөллийн 2023 оноос эхлүүлсэн бөгөөд уг аяны хүрээнд тамхины хяналтын тухай хуулийн дагуу эмнэлгийн гадна талбайд зөвшөөрөгдсөн бүсэд стандарт бүхий тамхины цэгийг байгуулсан бөгөөд хуулийн 9.1.6, 9.1.8-д заасны дагуу эмнэлгийн гадаад болон дотоод орчинд утаат тамхи татахыг хориглож, эмнэлгийн ойр орчмын байгууллагуудад зөвшөөрөгдсөн цэгээс бусад цэгт тамхи татахгүй байх, эмнэлэг ногоон бүс чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг илгээж ажилласан. 2024 онд эмнэлгийн утаат	


				тамхи татдаг хэсгүүдэд хориглох тэмдэг тэмдэглэгээг байршуулсан бөгөөд электрон болон утаат тамхи татахгүй байхыг цахим орчинд өрнүүлэн ажиллаж байна. 2. УНТЭ-ийн Эцэг эхийн зөвлөлөөс 2024.04.16-ны зохион байгуулсан “Аав ээжийнхээ ажлын нэг өдөртэй танилцах” өдөрлөгт оролцсон ЕБС-ын 12-р ангийн 15 сурагчдад УХТ-ийн эмч Г.Анхболд “Электрон тамхины хор хөнөөл” сэдвээр зөвлөгөө мэдээлэл олгосон. 	
--	--	--	--	---	--

Зураг 1. Сургалтын явцаас

Үйл ажиллагааны чиглэл 2.3.
Хүний папилома вирус /ХПВ/-ийн эсрэг вакциныг үе шаттай нэвтрүүлэх

2.	Умайн хүзүүний хавдраас урьдчилан сэргийлэх, хүний папилома вирусийн эсрэг дархлаажуулалтыг нэвтрүүлэх ухуулга, нөлөөллийн уулзалтыг зохион байгуулах	Эрүүл мэндийн болон салбарын оролцоог хангасан ухуулга, нөлөөллийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна.			ЭМЯ-наас 2024 оны 11дүгээр сарын 19-ны өдөр Олон нийтэд ХПВ-ийн талаарх мэдлэг мэдээлэл өгөх, ач холбогдлыг нь таниулах, Дархлаажуулалтын талаарх мэдээ, мэдээллийг түгээхэд ЭМБ-ын хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг нэгтгэх зорилгоор эрүүл мэндийн салбарын байгууллагуудын хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтнуудын ХПВ-ийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, ЭМЯ-наас хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл өгөх сургалтыг зохион байгуулсан бөгөөд УНТЭ-ийн НЭМА-ны дарга Г.Алтанцоо, НЭМА-ны мэргэжилтэн Д.Гандулам нар сургалтанд хамрагдаж санал бодлоо илэрхийллээ.  Зураг 2. Сургалтын явцаас	
ЗОРИЛТ 3. Хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээг байгуулан, оношилгооны чадамжийг сайжруулах Үйл ажиллагааны чиглэл 3.1.						

Хорт хавдрын урдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн үндэсний сүлжээг Хавдар судлалын үндэсний төвийг түшиглэн нэгдсэн удирдлагын дор эрт илрүүлгийн төв болон 21 аймаг, 9 дүүрэгт эрт илрүүлгийн нэгжийг байгуулах						
3.	3.1.5 Хавдрын эрт илрүүлгийн чанарын баталгаажилтын тогтолцоог бүрдүүлэх	Чанарын баталгаажилтын зөв тогтолцоо бүрдсэн байна.	-	-	1. Эрүүл мэндийн яамны урилгаар Монгол улсын хавдрын тусламж үйлчилгээ, оношилгоо, эмчилгээний чадамжийг тогтоох зорилгоор Олон улсын атомын энергийн агентлаг, Олон улсын хавдар судлалын агентлаг, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хамтран манай улсад хавдрын хяналтын чиглэлээр цогц үнэлгээ хийхээр ирсэн билээ. Энэхүү ажлын хүрээнд олон улсын баг 2024.05.17-ны өдөр Улсын Нэгдүгээр Төв эмнэлэг дээр хүрэлцэн ирж эмнэлгийн удирдлагуудтай уулзаж, хавдрын тусламж үйлчилгээний чиглэлээр мэдээлэл солилцсон бөгөөд олон улсын баг эмнэлгийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаатай танилцахаас гадна хавдрын тусламж үйлчилгээ үзүүлдэг Урологи-андрологийн төв, Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг, Цусны эмгэг, чөмөг шилжүүлэн суулгах төв, Эмнэлзүйн эмгэг судлалын төв лаборатори, Дүрс оношилгооны төв болон Цөмийн оношзүйн тасгуудад тус тус ажиллаж цаашид хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн уулзалт болсон.	



Зураг 3. Уулзалтын явцаас

2. Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг нь МУЗГ, ЭМЯ-наас санаачлан хэрэгжүүлж буй “Хүн амын нас, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоо”-г ЭМДТ дээр зохион байгуулж СБД-н I-VI хороо, ЧД 17-19 хороотой хамтран 18-с дээш насны хүн амыг эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамруулан ажиллаж байна. 2024 оны 10 сарын байдлаар 1278 иргэнийг эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамруулснаас 59 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Үзлэгт хамрагдсан иргэдийн 40-с дээш насны

					иргэнийг ЭМС-ын 2023 оны A/379 тоот тушаалын дагуу хөхний хэт авиан үзлэг шинжилгээг хийж ажилласан.Үзлэгийн явцад эмгэг өөрчлөлттэй, нарийн шинжилгээ хийлгэх шаардлагатай иргэдийг дараагийн шатны нарийн мэргэжлийн эмнэлэгт шилжүүлэх, хөхний нарийн мэргэжлийн үзлэгт хамруулан ажиллаж байна. Мөн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд товлот насны /30,33,36,39,42,45,48,51,54,57,60/ эмэгтэйчүүдэд пап эсийн буюу умайн хүзүүний хорт хавдар болон хавдрын урьдал эмгэгийг эрт илрүүлэх шинжилгээг хийж байгаа бөгөөд 2024 оны 11 сарын байдлаар 187 эмэгтэй үйлчлүүлэгчдээс шинжилгээ авснаас 9 иргэнд хавдрын урьдал эмгэг илэрсэн ба дараагийн шатлалд шилжүүлэн онош тодруулахаар илгээн ажилласан байна. 	
					Зураг 4. Үзлэгийн явцаас	

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

ХАРШЛААС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр /сая төг/		
Зорилго: Харшлын эрсдэлт хүчин зүйлийг бууруулан, урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах замаар харшлын шалтгаант өвчлөл, түүний хүндрэлийг бууруулах						
Зорилт 1.2 Харшлын өвчний оношилгоо, эмчилгээг сайжруулахад чиглэсэн бодлого, эрх зүйн орчинг бүрдүүлж сайжруулах						
1.	1.2.1 Харшлын арьс хатгах, арьс бигнэх сорилын үйлдлийн стандартыг боловсруулж батлуулах	Эрүүл мэндийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан байна.	-	-	1. УНТЭ-ийн Уушги, харшил судлалын төвийн эмч нар Харшлын арьс хатгах, арьс бигнэх сорилын үйлдлийн стандартыг боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд MNS6900:2021 стандартыг “Стандарт, хэмжил зүйн газар”-аар 2021 онд батлуулсан. 2. УНТЭ-ийн УХТөв нь 2023 оноос эхлэн арьс бигнэх сорилыг амбулаторит хийж эхэлсэн ба цусанд харшлын уургийг үзэх шинжилгээг хийж байна. 3. Уушги харшлын төв нь Монгол улсын харшлын лавлагаа мэдээллийн төвийнхөө	

					хувьд эмийн харшлын сорилыг хийж буй ганц эмнэлэг юм.	
	1.2.3 Гуурсан хоолойн багтрааны спирометрийн оношлогооны үйлдлийн стандартыг боловсруулж, батлуулах	Эрүүл мэндийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан байна.	-	-	УНТЭ-ийн Уушги, харшил судлалын төвийн эмч нар спирометрийн стандартыг боловсруулах багт орж ажилласан бөгөөд Спирометрийн шинжилгээ хийх аргачлал MNS6101:2022 стандартыг “Стандарт, хэмжил зүйн газар”-аар 2022 онд батлуулсан.	
2.	1.2.5 Гуурсан хоолойн багтраа өвчний эмнэлзүйн зааврыг шинэчлэн боловсруулж батлуулах	Эрүүл мэндийн ажилтнуудад сургалт зохион байгуулсан байна.	-	-	УНТЭ-ийн Уушги харшил судлалын төвийн эмч нар УГТЭ-ийн эмч нартай хамтран уушгины архаг бөглөрөлт өвчний оношилгоо, гуурсан хоолой тэлэгдэх өвчний оношилгооны эмнэлзүйн зааврыг шинэчлэн боловсруулах багт орж ажилласан бөгөөд ЭМС-ын 2022 оны А/130 тоот тушаалаар батлуулсан.	
3.	Багтраа өвчний хяналтын төлөвлөгөө боловсруулах, хүндрэл сэдрэлээс сэргийлэх	Хяналтын зааврын сургалт зохион байгуулсан байна.			УНТЭ-ийн УХТ нь гуурсан хоолойн багтраа өвчнийг амбулаториор хянаж давтан үзлэгийн бүртгэлийг сайжруулснаар хяналтыг төгөлдөржүүлж тус оношоор хэвтэх хэвтэлтийг эрс бууруулсан бөгөөд гуурсан хоолойн багтраа өвчний оношилгоо, хяналтыг сайжруулахын тулд спирометрийн шинжилгээний стандартыг шинэчлэн боловсруулж, Стандарт хэмжилзүйн үндэсний төвөөр батлуулан хэрэглэж байна. Гуурсан хоолойн багтраа өвчтэй үйлчлүүлэгчдэд	

					зориулан цацлагын эмийг хэрхэн зөв сорох талаар ханын үзүүлэн бэлтгэж, УНТЭ-ийн амбулаторын хананд байршуулсан.	
Үйл ажиллагааны чиглэл 1.3 Харшлын өвчний эмнэлгийн тусламж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгоход чиглэсэн бодлого, эрх зүйн орчинг бүрдүүлэх сайжруулах						
4	1.3.3 Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, БОӨТ-ийн эмнэлзүйн харшил судлалын эмчийг орон тоогоор ажиллуулах	Эмнэлзүйн харшил судлалын эмчийг орон тоогоор ажиллуулсан байна.			УНТЭ-ийн Уушиг харшлын тасагт харшил судлалын эмчийг орон тоогоор 1 эмчийг ажиллуулж байна.	
Зорилт 2. Харшлын эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хүн амын мэдлэгийг дээшлүүлэх						
Үйл ажиллагааны чиглэл 2.2 Харшлаас урьдчилан сэргийлэх талаар хүн амын дунд мэдээлэ, сургалт, суртчилгаа хийх, олон нийтийн санаачллыг дэмжих						

5.	2.2.2 Эмийн харшлаас сэргийлэх, антибиотикийн хэрэглээг зөв зохистой болгох мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах	Цахим судалгааны үр дүнг үндэслэн МСС-ны бүтээгдэхүүн боловсруулж түгээсэн байна.	-	-	1. УНТЭ нь хүн амд Эмийн харшлаас сэргийлэх, антибиотикийн хэрэглээг зөв зохистой болгох мэдээлэл, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд өөрийн байгууллагын албан ёсны фэйсбүүк фэйж хаяг болон гадаад вэб сайт дээрээ эмийн харшлаас сэргийлэх, антибиотикийн хэрэглээг зөв зохистой хэрэглэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол давтамжтайгаар ард иргэдэд ойлгомжтой байдлаар байршуулан ажиллаж байна. Мөн цацлага эм хэрэглэх шаардлагатай үйлчлүүлэгчдэд эмийн харшлын талаар болон антибиотикийн гаж нөлөөний талаарх сургалтуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. 2. Жил бүрийн 11-р сарын Эрүүл мэндийн яам, Улсын Нэгдүгээр төв эмнэлэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, ДЭМБ хамтран “Бичил биетний тэсвэржилтийн талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх” аяныг “Мэдлэг олгоё. Нөлөөлье. Яг одоо” уриатайгаар зохион байгуулж байгаа бөгөөд аяны хүрээнд эмийн хог хаягдалыг цуглуулан байгальд ээлтэйгээр утсгууллаа. Мөн “Бичил биетний тэсвэржилтээс хамтдаа сэргийлье” сэдэвт танхимын болон
----	--	---	---	---	---

[illegible]

					баталгаажуулах” журмаар зохицуулагдаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 04-өөс 10-ны өдрийн хооронд “Гаж нөлөөнөөс урьдчилан сэргийлье” уриан дор“ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДОЛОО ХОНОГ” аянд нэгдэн аяны хүрээнд иргэдийн эмийн гаж нөлөөний талаарх ойлголт, мэдлэгийг сайжруулах, эмийн гаж нөлөөнөөс сэргийлэх, гаж нөлөөг хэрхэн мэдээлэх, мэдээлэхийн ач холбогдлыг олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан таниулан сурталчилахад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан. Улсын хэмжээнд 2017-2024 онуудад эмийн гаж нөлөөний тохиолдол нийт 880 үндэсний мэдээний санд бүртгэгдсэн байна. ЭЭХХЗГ нь мэдээлэгдсэн гаж нөлөөний тохиолдол бүрийг үнэлж, тухай бүр Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн үнэлгээг баталгаажуулан, шаардлагатай тохиолдлуудад зохицуулалтын шийдвэр, зөвлөмжийг гарган эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	--

						
--	--	--	--	--	---	--

Зураг 2. Зөвлөмж

Зорилт 3
Харшлын өвчний оношилгоо, эмчилгээний менежментийг боловсронгуй болгох, хүндрэлийг бууруулах

Үйл ажиллагааны чиглэл 3.1
Харшил, харшлын шалтгаант өвлөлийн оношилгооны чадамжийг сайжруулан, лабораторийг бэхжүүлэх

6.	3.1.3 Анафилаксийн шокийн үед яаралтай үзүүлэх талаар боловсролын байгууллагын эмч нар сургалт зохион байгуулах	Нийслэлийн сургуулийн эмч нарт сургалт зохион байгуулсан байна.	-	-	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн ЯТТ, УХТ нь анафилаксийн шокийн үед үзүүлэх яаралтай тусламжийн алгоритм бүхий зөвлөгөө мэдээллийн баннерийг эрхлэн гаргасан бөгөөд ЕБС-ийн Наран сургууль, 21-р сургууль, эмнэлгийн амбулаторын хэсгүүдэд байршуулсан. 	
----	---	---	---	---	--	--

Зураг 3 . Зөвлөмж

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ
ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ЭР ХҮН АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр /сая төг/		
Зорилго: Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, тэдэнд хүрэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, дундаж наслалтыг нэмэгдүүлэх орчин нөхцлийг бүрдүүлнэ.						
Зорилт 1. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй бодлого, эрхзүйн орчинг боловсронгуй болгох						
1	1.4“Түрүү булчирхайн хоргүй хавдрын оношилгоо эмчилгээ” MNS6100:2010 стандартыг шинэчлэх	Стандартыг батлуулсан байна.			УНТЭ-ийн Урологи андрологийн төвийн эмч нар Түрүү булчирхайн хоргүй хавдрын оношилгоо эмчилгээ стандартыг боловсруулах багт орж ажиллаж байгаа бөгөөд стандартыг “Стандарт, хэмжил зүйн газар”-аар батлуулахаар ажиллаж байна.	

1	1.5 Бөөрний чулууны оношилгоо, эмчилгээ MNS6099:2010 стандартыг шинэчлэх	Стандартыг батлуулсан байна.			УНТЭ-ийн Урологи андрологийн төвийн эмч нар Бөөрний чулууны оношилгоо, эмчилгээ стандартыг боловсруулах багт орж ажиллаж байгаа бөгөөд стандартыг “Стандарт, хэмжил зүйн газар”-аар батлуулахаар ажиллаж байна.	
1.	1.6 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, кабинетийн үлгэрчилсэн загвар, ажиллах журам боловсруулан батлуулах	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	-	-	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 13-р зүйлийн 13.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2020 оны 07 сарын 01-ний өдрийн дугаар 99-р захирамжаар батлагдсан “Эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.3 дахь заалтын хүрээнд төрөөс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээ бий болгох зорилгын дор УНТЭ-ийн Урологи андрологийн төв нь ‘Эрэгтэйчүүдийн кабинетын үлгэрчилсэн загвар, ажиллах журам батлах тухай тушаалыг боловсруулж уг журмыг ЭМС-ын 2022 оын 09 сарын 05 өдрийн А/449 тоот тушаалаар батлуулан журмын дагуу хүн амд тусламж үйлчилгээ хүргэн ажиллаж байна.	

Зорилт 2. Бүх шатны бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид, байгууллага хамт олон, гэр бүл болон эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх

2.	2.10 Цэрэг арми, батлан хамгаалах, хил хамгаалах, уул уурхай, барилга, зам тээврийн чиглэлээр ажиллаж буй компаниудын нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах цахим болон танхимын сургалт явуулах	Хамтран ажиллаж буй байгууллагын тоо, үйл ажиллагааны тайлан	-	-	1. УНТЭ-ийн ШШГЕГ-тай хамтын ажиллагааны хүрээнд танхим болон цахим сургалтыг 2023 оноос эхлэн зохион байгуулан ажиллаж байна. Уг үйл ажиллагааны хүрээнд 2024 оны 01 сарын 31-ны өдөр НЭМА-ны сэтгэц, сэтгэл заслын их эмч А.Оюунжаргал “Сэтгэцийн эрүүл мэнд, эрэгтэйчүүдийн сэтгэл зүйн байдал, сэтгэл гутрал, сэтгэл мэдрэмжээ хуваалцах арга зүй”, НЭМА-ны хоолзүйч Э.Санчир “Хооллолт ба шим тэжээл” сэдвийн хүрээнд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, зөвлөгөө өгөх танхимын сургалтыг зохион байгуулсан. Уг сургалтанд нийт 30 гаруй албан хаагч хамрагдсан бөгөөд цахимаар холбогдож мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.  Зураг 1. Сургалтын явцаас	
----	---	--	---	---	---	--

					2.УНТЭ нь АПУ ХК-ны хамтын ажиллагааны хүрээнд эрэгтэйчүүд олноор ажилладаг Апу Трэйдинг ХХК-ны түгээлтийн жолооч нарт 2024.03.12-2024.03.13 өдрүүдэд НЭМА-ны сэтгэц, сэтгэл заслын эмч А.Оюунжаргал “Стрессээ менежмент”, “Стрессийн шалтгаант хямрал”, хоолзүйч Э.Санчир “Хооллолтын илчлэг тооцох арга, ажлын байрны онцлог хооллолт, стрессийн үеийн хоол шим тэжээл” сэдвүүдээр танхимын сургалт зохион байгуулсан сургалтанд нийтдээ 70 гаруй түгээлтийн ажилтан, жолооч нар хамрагдсан. Сургалтын төгсгөлд ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих цуврал контентод оролцсон.  <i>Зураг 2. Контентод яриа өгөх явцаас</i>	
--	--	--	--	--	---	--

Зорилт 3
Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах

3	3.3 Онко урологийн оношилгоо, эмчилгээг олон				УНТЭ-ийн Урологи-Андрологийн төв нь Олон улсын сайн дурын Урологийн нийгэмлэгтэй хамтран Давсагны хорт хавдар авах мэс засал	
---	--	--	--	--	--	--

	улсын жишигт хүргэж, дурангийн мэс заслыг нэвтрүүлэх				болон шээсний сүвний нарийслыг эмчлэх мэс заслыг амжилттай хийсэн. Олон улсын сайн дурын Урологийн нийгэмлэг нь 2006 оноос хойш УНТЭ-ийн Урологи-Андрологийн төвтэй хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд олон улсын шинэ арга, технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ажлын байрны сургалт зохион байгуулах үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж байна. Тус хамтын ажиллагааны хүрээнд шээсний сүвний төрөлхийн гажиг гэсэн оноштой хүүхдүүдэд мэс засал засал, бөөр шээсний замын чулуу авах мэс засал, хавдрын мэс заслыг хийж байсан бол энэ удаад шээсний сүвний нарийслыг эмчлэх баг ирж 25 иргэнд шээсний сүвний олон дахисан нарийслыг эмчлэх мэс засал хийж, хоёр өвчтөнд давсагны хавдар авах мэс заслыг хамтран амжилттай хийсэн	
--	---	--	--	--	---	--

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

ЭРҮҮЛ ИДЭВХИТЭЙ АМЬДРАЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН


Д/Д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр /сая төг/		
Зорилго . Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжиж, иргэн бүрт эрүүл, идэвхитэй амьдралын хэв маягыг төлөвшүүлэх						
Зорилт 2. Эрүүл, идэвхитэй амьдралыг дэмжсэн дэд бүтцийг хүн амын ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй болгох						
1.	2.20. Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамрагдах эрүүл мэндийг дэмжих төвийг эрт илрүүлгийн төвийг байгуулах	Эрт илрүүлгийн төвийн үйл ажиллагаа тогтмолжсон байна.	-	-	Улсын Нэгдүгээр төв эмнэлэг нь олон улсын стандартад нийцсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ, оношилгооны иж бүрэн төв болох “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг 2020 оны 06-р сарын 22-ны өдөр нээсэн бөгөөд коронавируст цар тахлын нөлөөнөөс үүдэж 2021 оны 08 сараас албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Уг төв нь байгууллага, хувь хүнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлгийг эрүүл мэндийн тусгай багцаар үзүүлэн тусламж үйлчилгээг хүргэн ажилладаг бөгөөд хувь хүнд үзлэгийн дүгнэлтэнд үндэслэн цаашид авах эрүүл мэндийн арга хэмжээнд чиглүүлж сэтгэцийн эрүүл мэнд болон хоолзүйн зөвлөгөөг тусгайлан өгдөгөөрөө онцлогтой юм.	

УНТЭ-ийн ЭМДТ нь 2024 онд Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас “Эрүүл мэнд үндэсний баялаг” уриан дор явагдаж буй “Хүн амын нас, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоо”-нд Сүхбаатар I-VI хороо, Чингэлтэй дүүргийн 17-19 хорооны 18-с дээш насны 875 иргэнийг 4 насны багцаар үзлэгт хамруулан ажилласан бол байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэгээр 1278 иргэнийг хамруулсан байна.



Зураг 1. Үзлэгийн явцаас

2.	2.25. Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын вэб сайтад “Эмч зөвлөж байна” линк үүсгэн эмч нарын зөвлөгөө, шинэ дэвшилтэт технологи, асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл, яриа лекцийг тогтмол тавьж ажиллуулах	Вэб хэрэглээ нэмэгдсэн байна.	хуудасны нэмэгдсэн	-	-	Улсын Нэгдүгээр Төв эмнэлэг нь байгууллагын мэдээллийн гадаад вэбсайт, фэйсбүүк фэйж хуудас зэрэг иргэдийн хамгийн түгээмэл ашигладаг цахим сувгуудаар дамжуулан ДЭМБ,ЭМЯ,НЭМҮТ-өөс эрхлэн гаргаж буй хүн амын эрүүл мэндийг боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр хийгдэж буй контент, шторк, зөвлөгөө мэдээллийг тогтмол байршуулан түгээн ажиллаж байна. Мөн хүн амын дунд зонхилон тохиолддог өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээллийг ярилцлага хэлбэрээр бэлтгэн байршуулан ажиллаж байна. УНТЭ-с бэлтгэн хүргэдэг “УНТЭ-ийн 7 хоногийн тойм мэдээ” 5-10 минутын видео контентод “Эмч зөвлөж байна”, “Сувилагч зөвлөж байна” буланг үүсгэсэн бөгөөд хүн амын дунд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, шинэ технологийн талаарх мэдээллийг бэлтгэн иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар фэйсбүүк хуудас болон youtube хаягуудад байршуулан хүргэн ажиллаж байна.	
----	---	-------------------------------	--------------------	---	---	---	--



Зураг 2. Мэдээлэл байршуулсан явцаас

Зорилт 2 Эрүүл идэвхитэй амьдралыг дэмжсэн дэд бүтцийг хүн амын ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй болгох

3.	2.33. Эрүүл идэвхитэй амьдралыг дэмжсэн дэд бүтцийн салбар дундын зөвлөгөөн, үзэсгэлэн зохион байгуулах	Салбар дундын зөвлөгөөн үзэсгэлэн зохион байгуулах ажил тогтмолжсон байна.	-	-	ЭМЯ,НЭМҮТ хамтран “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024” эрүүл мэндийн өдөрлөгийг 2024.05.22-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Уг өдөрлөгийн арга хэмжээнд Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг нь артерийн даралт болон цусан дахь сахарыг түргэвчилсэн аргаар хэмжих, хоол зүй, шим тэжээлийн зөвлөгөө өгөх, биеийн бүтэц, найрлага тодорхойлох, эрүүл зөв хооллолт, идэвхитэй дасгал хөдөлгөөний зөвлөгөөг ард иргэдэд өгч ажилласан. Өдөрлөгт оролцсон 70 иргэний артерийн даралтыг хэмжиж зүрх судасны үеийн зөвлөгөө мэдээлэл, цусан дахь сахарын түргэвчилсэн шинжилгээг 121 иргэнд хийснээс чихрийн шижин өвчин оношлогдсон 6 иргэнд дотоод шүүрлийн эмчийн үзлэг зөвлөгөө өгч, цаг товлон үйлчилгээ үзүүлэн ажилласан ба биеийн бүтэц найрлага тодорхойлох Inbody аппаратаар 45 иргэнд хэмжилт хийж эрүүл зөв хооллолт, таргалалтын үеийн хоол шим тэжээл, эрүүл амьдралын зөвлөгөөг өгч ажилласан.  
----	---	--	---	---	---

						
Зорилт 3. Эрүүл идэвхитэй хөдөлгөөнийг эрхэмлэх нийгмийн сэтгэлзүйг төлөвшүүлэх						
4.	3.44. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн дасгал, хөдөлгөөн, бүжиг, иог, алхалт, гүйлт, дугуйн болон бусад идэвхитэй хөдөлгөөний дэмжсэн дэлхийн болон үндэсний	Олон нийтэд ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна.	-	-	ЭМЯ-наас санаачлан хэрэгжүүлсэн “Энэ жилдээ-Эрүүл жиндээ 2” аяны хүрээнд нийт ажилтнуудынхаа дунд идэвхитэй хөдөлгөөнөөр хичээллэхийг дэмжих, ажлын байрны хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн биеийн тамирын спортыг дэмжих замаар таргалалтыг бууруулах чиглэлээр УНТЭ-ийн нийт ажилтнуудад зориулж иогийн тусгай сургалтыг зохион байгуулан ажиллаж	

Зураг 3. Өдөрлөгийн явцаас

	өдрийг тэмдэглэхэд дэмжлэг үзүүлэх			байна. Уг сургалтыг Stay Yoga Олон улсын иогийн сургуулийг албан ёсны багшийн сертификаттай /RYT 200/ төгссөн Ө.Одончимэг багш удирдан явуулдаг.Иогийн сургалтын зарыг түгээхдээ нийт ажилтнуудын албан ёсны и-мэйл хаяг руу сар бүр дэлгэрэнгүй мэдээлэл илгээдэг бөгөөд ажилтнуудын ажлын ачааллал, нөхцөл боломжийг харгалзан үзэж өөрийн эмнэлгийн нөөц бололцоонд тулгуурлан өөрийн ажлын байран дээр буюу Сэргээн засах эмчилгээний тасгийн зааланд Даваа, Лхагва, Баасан гарагуудад тогтсон цагийн хуваарийн дагуу иогийн сургалтыг 3 дахь жилдээ зохион зохион байгуулан явуулж байна. Уг сургалтанд 2024 оны байдлаар нийтдээ давхардсан тоогоор 100 гаруй ажилтнууд хамрагдсан бөгөөд шинэ элсэлтийг сар бүр авч анги бүрдүүлэлт хийж байна. 	
--	---	--	--	--	--

					<i>Зураг 4. Иогийн сургалтын явцаас</i> УНТЭ-ийн нийт ажилтнуудын идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих зорилгоор фитнесийн өрөөг тохижуулан ажиллаж байна 	
Зорилт 4. Эрүүл, зөв, зохистой хооллолтыг дэмжсэн нийгмийн орчинг бүрдүүлэх						
5.	4.48. Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар олон нийтэд чиглэсэн ухуулга нөлөөллийн арга хэмжээг хамтран зохион байгуулах	Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гарсан байна.	-	-	1. УНТЭ-ийн хоолзүйч Э.Санчир нь 2024.05.01-ний өдөр Багануур ХК-ны 200 гаруй ажилтанд “Гэдэсний эрүүл мэнд, Хүнсний эрүүл ахуй, Хүнсний аюулгүй байдал” зэрэг сэдвүүдээр танхимын сургалт зохион байгуулсан бөгөөд цаашид цахимаар зохион байгуулахаар төлөвлөж байна.	



Зураг 5. Сургалтын явцаас

2. 2024/11/10 -нд Дэлхийн чихрийн шижингийн өдрийг тохиолдуулан "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ ажилтнуудад "Чихрийн шижин ба эрүүл мэнд" сэдвээр өдөрлөг зохион байгуулсан



Зураг 6. Сургалтын явцаас

3. 2024/09/21-2024/09/22 - нд ЭМЯ болон “Монголын хоолзүйчдийн холбоо” зохион байгуулсан эх хүүхдийн эрүүл мэндэд зориулсан Wellbeing Expo -нд оролцож “Өсвөр насны хооллолт” сэдвээр сургалт

					явуулсан. Мөн 2 өдөр өдөрлөгт хоол зүйн зөвлөгөө өгч ажилласан.  Зураг 7. Сургалтын явцаас	
6.	4.50. Хүн амын насны бүлэг, өвөрмөц бүлэг бүрт тохирсон зохистой хооллолтын зөвлөгөө өгөх, контент боловсруулах, түгээх	Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байна.	-	-	4. УНТЭ-ийн хоолзүйч Э.Санчир нь 2024.02.19 Mongol HD телевизийн Terminal 1.0, 2024.05.15-ны өдөр Mongol HD телевизийн Нүүдэл-Шийдэл, нэвтрүүлэгт оролцож хүн амын дундах хооллолт, өвөрмөц бүлгийн хоол шим тэжээлийн талаар зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.  Зураг 8. Нэвтрүүлэг контентийн явцаас 5. УНТЭ-ийн НЭМА нь 2024.11.14 Дэлхий нийтийн чихрийн шижинтэй эсрэг тэнцэх өдрийг Эйндромеда ХХК-тай хамтран	

					Inbody-мэргэжлийн төхөөрөмжүүдээр эмнэлгээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгч нарт биеийн бүтцийн шинжилгээг хийж НЭМА-ны хоолзүйч Э.Санчир ньTV9 телевизийн мэдээ мэдээллийн хөтөлбөрөөр чихрийн шижинтэй хүмүүст хоол шим тэжээлийн талаар зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.  Зураг 9. Зөвлөгөө,мэдээлэл өгөх явцаас	
--	--	--	--	--	--	--

Зорилт 5. Сэтгэц, зан үйл, танин мэдэхүйн эрүүл мэндийг дэмжсэн нийгмийн орчинг бүрдүүлэх

6.	5.59.Тамхины хяналтын тухай хууль, тамхины хяналтын суурь конвенцийг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд “Тамхигүй орчин бүрдүүлэх” ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах,	Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд контентийг таниулсан байна.	-	-	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн НЭМАлба нь тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эмнэлгийн орчин дахь эрүүл аюулгүй ажлын байр бүрдүүлэх, дам тамхидалтанд өртөхөөс урьдчилан сэргийлэх, ажлын хүрээнд “Эмнэлэг тамхигүй ногоон бүс” ухуулга нөлөөллийн аяныг 2023 онд эхлүүлсэн. Уг аяны хүрээнд тамхины хяналтын тухай хуулийн 5.2.5-д заасны дагуу эмнэлгийн гадна талбайд зөвшөөрөгдсөн бүсэд стандарт бүхий тамхины цэгийг байгуулсан бөгөөд хуулийн 9.1.6, 9.1.8-д	
----	--	---	---	---	--	--

заасны дагуу эмнэлгийн гадаад болон дотоод орчинд утаат тамхи татахыг хориглож, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хордуулахгүй байхыг уриалж зөвшөөрөгдсөн цэгээс бусад цэгт тамхи татахыг хориглосон тэмдэглэгээнүүдийг байршуулсан. Мөн эмнэлгийн ойр орчмын байгууллагуудыг зөвшөөрөгдсөн цэгээс бусад газарт тамхи татахгүй байх, бусдыг дам тамхидалтанд өртүүлэхгүй байхыг уриалж хамтран ажиллах санамж бичиг илгээж ажилласан.




Зураг 10. Эмнэлэг-Тамхигүй орчин нөлөөллийн ажлын явцаас

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

№	Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ /заалт/	Шалгуур үзүүлэлт	/хүрэх түвшин/	Хэрэгжилт
1.2	Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагдах халдварт өачин, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал. халдварт өвчийн тандалтын тогтолцоог бэхжүүлэх, тогтвортой байдлыг хангах	1.2.1 Халдварт өвчний хэтийн төлөв, хандлагыг тооцож бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтвортой байдлыг хангах		Хэтийн төлөвт үндэслэн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангасан байна.	Тайлант хугацаанд ЭМС-ын 2018 оны А/527 тоот тушаалын дагуу олон улсын дүрмээр зохицуулагддаг шинэ болон сэргэж буй халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах чиглэлээр УНТЭ-т ирсэн халдварт болон халдвар бус өвчинд тандалт судалгааг тогтмол хийн ХӨСҮТ-д мэдэллэх, шилжүүлэх зэрэг шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 оны 1-10 сарын байдлаар УНТЭ-т халдварт өвчний нийт 22 тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнд: ✓ Сүрьеэгийн халдварын батлагдсан 5 тохиолдол ✓ HIV-р үүсгэгдэх халдварын 5 тохиолдол ✓ Салхинцэцгийн вирусээр үүсгэгдэх халдварын сэжигтэй 1 тохиолдол ✓ Хачгаар дамжих халдварын сэжигтэй 4 тохиолдол ✓ Улаанбурханы сэжигтэй 3 тохиолдол Эдгээр тохиолдлуудыг ЭМС-ын А/527 тоот тушаал болон ЭМС-ын А/160 тоот тушаалуудыг үндэслэн холбогдох дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд: ✓ Тусгаарлан шилжүүлэх арга хэмжээ

					1. ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР Тайлант хугацаанд ЭМС-ын А/91 тоот тушаалыг үндэслэн улаанбурхан халдварт өвчин тархах эрсдэлээс сэргийлэн эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтыг хуудсыг боловсруулж амбулатори, яаралтай тусламжийн тасаг, шуурхай зохион байгуулалтын хэсэг, эрүүл мэндийн даатгалын хэсгүүдэд байршуулсан. Мөн тандалт хийх ажилтныг тусад нь томилж хэвтэн эмчлүүлэгчдийг шинж тэмдэггүй тохиолдолд тандалтын хуудсыг нээж өвчний түүхэнд хавсарган тасагт хэвтсэн өдрөөс гарах хүртэлх хугацаанд өдөр бүр тандаж байгаа бөгөөд эмнэлгийн ажилчдын дундах тандалтыг ЭМТҮЧАБА-нд мэдээллэж сэжигтэй тохиолдолд холбогдох албанд хүргүүлэн шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2. СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ЭМС-ын А/537, А/91, А/528 тоот тушаалуудыг үндэслэн Улаан бурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, авах хариу арга хэмжээний талаарх хичээлийг бэлтгэн 2024 оны 08 сарын
--	--	--	--	--	---

				04,07,08,13,14 өдрүүдэд эмнэлгийн төв тасаг, дэмжих албадуудын нийт эмч ажилчдад сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан. Сургалтанд нийт 485 эмч ажилтнууд хамрагдсан байна.  3. ГАМШГИЙН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛЫН ЧИГЛЭЛЭЭР Эмнэлгийн гамшгийн үед авах хариу арга хэмжээ, бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж халдварын сэжигтэй тохиолдолд эмнэлэг дотор ямар хариу арга хэмжээ авах, халдварын тархалтын түвшинг хэрхэн бага байхаар зохион байгуулах талаар эмнэлзүйн багаараа хэлэлцэн 3 төрлийн алгоритмийг боловсруулж төв тасгуудад байршуулах, мэдээллийг хүргэх зэргээр мөрдөн ажиллаж байна.
--	--	--	--	--


				4. ТУСГААРЛАХ ӨРӨӨНИЙ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР Дээрх тушаалуудыг үндэслэн халдварын сэжигтэй, халууралт, тууралттай тохиолдлыг тусгаарлан яаралтай мэдээлэх зохион байгуулалтыг хийж яаралтай тусламжийн тасаг, эрчимт эмчилгээний тасаг, хэвтэн эмчлүүлэх тасгуудад тус бүр тусгаарлах өрөөг бэлтгэн бэлэн байдлыг хангуулсан. Мөн Эмнэлэгт бөөгнөрөл үүсгэхээс сэргийлж амбулаторийн үзлэгийн цагийг утас болон цахимаар олгон эмнэлгээр үйлчлүүлж байгаа иргэдэд амны хаалт хэрэглэхийг шаардан халууныг үзэж нэвтрүүлж байна.
--	--	--	--	---



5. ЦЭВЭРЛЭГЭЭ ХАЛДВАРГҮЙТГЭЛ, АГААР ДУСЛЫН ЗАМААР ХАЛДВАР ДАМЖИХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Халдвар агаар дуслаар дамжин тархахаас сэргийлж эмнэлгийн хэмжээнд төв, тасаг тус бүрээр хуваарь боловсруулан батлуулж агаарт халдваргүйтгэлийг тогтмол хийлгэн, тасгуудын дотоод талбайн их цэвэрлэгээний давтамжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.



					6. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ХАМГААЛАХ ХУВЦАС ХЭРГЭСЛЭЛИЙН НӨӨЦИЙН БЭЛЭН БАЙДАЛЫГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн байгууллагын нөөцөд байх эм эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, оношлуурын нөөцийн мэдээг 2024 оны 08 сарын 08-ны өдрөөс эхлэн өдөр бүр 9 цагт ЭМТҮЧАБА-нд мэдээг ирүүлэн ажиллаж байна.   7. ЭМЧ,ЭМНЭЛГИЙН АЖИЛТНУУДЫГ ДАРХЛААЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2024 оны 08 сарын 02-ны өдрөөс 2024 оны 8 сарын 07-ны хооронд эмнэлгийн ажилтнуудын дунд улаан бурхан өвчний эсрэг дархлаажуулалтанд хамрагдсан байдлын судалгааг тасаг тус бүрээр гаргасан. Судалгааг үндэслэн улаанбурхан өвчнөөр
--	--	--	--	--	--

[illegible]

УНТЭ-н байгууллагын мэдээллийн сувгууд болох гадаад вэб хуудас, фэйсбүүк фэйж (Улсын Нэгдүгээр Төв эмнэлэг, УНТЭ Нийгмийн Эрүүл Мэндийн Алба) хуудсуудаар дамжуулан өдөр бүр тогтмол байршуулан түгээн ажиллаж байна. 2024.08.02-ны өдрөөс хойш ЭМЯ, НЭМҮТ, ХӨСҮТ-өөс эрхлэн гаргаж буй улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх албан ёсны эх сурвалж бүхий постер зөвлөмж, контент болох 20 гаруй зөвлөмжийг цахим орчинд байршуулж мөн амбулаторийн

хүлээлгийн танхимуудын дэлгэц дээр байршуулан ажиллаж байна.



Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг/ The First Central Hospital of Mongolia

1 Aug · 📍

УЛААН БУРХАН ӨВЧНӨӨС СЭРГИЙЛБЕ

УЛААНБУРХАН ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Биеийн эсэргүүцлээ сайжруулж, дархлаагаа дэмжин ажил амьдралтаа эсхицуулж, чанартай хоол хүнс хэрэглэх

Онцмын шаавдлагагүй бол олон нийтийн







Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг/ The First Central Hospital of Mongolia

2 Aug · 📍

УЛААНБУРХАН ӨВЧНӨӨС СЭРГИЙЛБЕ.







Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг/ The First Central Hospital of Mongolia

5 Aug · 📍

УЛААНБУРХАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛБЕ.



Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг/ The First Central Hospital of Mongolia

6 Aug · 📍

ХҮҮХДЭЭ УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИНД ХАМРУУЛААРИЙ.






Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг/ The First Central Hospital of Mongolia

6 Aug · 📍

УЛААНБУРХАН ӨВЧНИЙ ҮЕД ИЛРЭХ ШИНЖ ТЭМДЭГ



7.1	Эрүүл мэндийн байгууллагуудын халдвараас сэргийлэх. хянах тогтолцоог бүх түвшинд бэхжүүлж, хуний нөөцийг чадавхижуулах	7.1.1 Эрүүл мэндийн байгууллагын халдвараас сэргийлэх, хянах тогтолцоог бэхжүүлэх	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн байна.	УНТЭ-ийн Халдварын сэргийлэлт, хяналтын (цаашид ХСХ) алба нь 2024 онд халдвараас сэргийлэх, эрт илрүүлэх, эрсдэлийг бууруулах, чанар сайжруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Мэс заслын анагаах ухааны эмнэлзүйн салбар зөвлөл, Дотрын анагаах ухааны эмнэлзүйн салбар зөвлөлийн үйл ажиллагааны 6 зорилт бүхий 13 төрлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажилласан ба жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна.
-----	--	---	---	---

Төлөвлөгөө баталсан:

Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (албан тушаал)

Тэмдэг

Төлөвлөгөөг боловсруулсан:

ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДАРГА (албан тушаал)

Тэмдэг

Төсвийн Шууд захирагч

Б.ХИШИГЖАРГАЛ (орлого)

МАН.Р.А.С

Нагжийн дарга

Б.НАМУУН (орлого)

2024.06.24

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН АЛБАНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дд	Стратегийн төлөвлөгөө болон үнэмсэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилготой түвшин	Хугацаа л-IV улирал	Хариуцах нэгж
ЗОРИЛГО: ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ							
ЗОРИЛТ 1: ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР							
1.1	ДЭМБ-ын 2019 оны зөвлөмж болон ЭМС-ын А/Б38 тоот тушаалын дагуу эмнэлзүйн тусламж үйлчилгээ үзүүлж буй тасгуудад ОЗТББ илэрсэн үйлчлүүлэгчийг тусгаарлан өмчлөх хэсгийг ОУ-ын стандартын дагуу зохион байгуулах		Батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулсан хэсэг, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны ажлын тайлан		ЭТҮХХ-ын эх уурхайг илрүүлэх, халдварыг таслан зогсоох	III-IV улирал	Эмнэлзүйн баг, ХСХ/Алба Эмнэлзүйн төв, тасгууд

--	--

Халдварын
сэргийлэлт
хяналтын чиглэлээр
мэргэжлийн
индекстэй болж
мэргэшүүлэх
сургалтыг жилд 2
удаа зохион
байгуулсан байна.

Тайлангийн хугацаанд ХСХА нь төв, тасгуудын халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр сургалтын хуваарь боловсруулан батлуулсан.

Эмнэлгийн эмч ажилчдын дунд батлагдсан хуваарийн дагуу халдварын сэргийлэлт халдварын сэргийлэлт, чиглэлээр ЭМС-ын А/537, 538 тоот тушаалын тушаалыг үндэслэн 7 сэдийн хүрээнд нийт нийт 9 тасагт чадавхижуулах, дадлагажуулах сургалтыг нийт 720 хүнийг хамруулан зохион байгуулж сургалтын өмнө болон дараа тестийн шалгалтыг авч асуулт хариулт хэлбэрээр ярилцан сургалтын тайланг тухай бүр бичин гарын үсгээр баталгаажуулсан.



Үүнд:

1. ЭТҮХХ-ын халдварын тандалт

2. Судасны гуурстай холбоотой халдвар
3. Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх заавар
4. Асгарсан цацагдсан цус биологийн шингэнийг хэрхэн зөв цэвэрлэх
5. Гарын эрүүл ахуй сахих


				6. Хамгаалах хувцас хэрэгслийг зөв өмсөж, аюулгүй тайлах дараалал 7. HIV-н халдвараас сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх үеийн менежмент 8. Улаанбурхан, Томуу төст өвчний халдвараас сэргийлэр арга хэмжээ <table><tr><th>№</th><th>Сургалтын сэдвүүд</th><th>Хамрагдсан тасаг, хүний тоо</th><th>Сургалтын он сар, тайланг тус бүр бичин гарын үсгээр баталгаажуулж тасагт хүргүүлэв.</th></tr><tr><td colspan="4">Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус</td></tr><tr><td>1</td><td>Судасны холбоотой халдвар ЭТҮХХ-ын халдварын тандалт</td><td> ✓ VIP- 12 ✓ ГЭТ-18 ✓ УАТ-16 ЭМЧ, сувилагч </td><td> </td></tr><tr><td>2</td><td>ХСХ-ын ерөнхий ойлголт Гарын эрүүл ахуй сахих</td><td> ✓ ЯТТ-21 ✓ ДОТ-11 ✓ VIP-12 ✓ ЕМЗТ-1,2 ЭМЧ, сувилагч </td><td> </td></tr><tr><td>3</td><td>ЭТҮХХ-ын ерөнхий ойлголт</td><td> ✓ ЦЭСЧШСТ-18 ✓ ЕМЗТ-23 ЭМЧ, сувилагч </td><td> </td></tr><tr><td>5</td><td>ЭМС-ын А/537 тоот тушаалын зургаадугаар хавсралтын дагуу Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх заавар болон ерөнхий зарчим</td><td>Мэс заслын болон дотрын тасгийн 36 үйлчлэгч</td><td> </td></tr><tr><td>6</td><td>HIV-н халдвараас сэргийлэх, тусламж үйлчилгээний менежмент ЭТҮХХ-ын тандалт, сэжигтэй тохиолдол</td><td>Нийт 150 эмч нар</td><td> </td></tr></table>	№	Сургалтын сэдвүүд	Хамрагдсан тасаг, хүний тоо	Сургалтын он сар, тайланг тус бүр бичин гарын үсгээр баталгаажуулж тасагт хүргүүлэв.	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус				1	Судасны холбоотой халдвар ЭТҮХХ-ын халдварын тандалт	✓ VIP- 12 ✓ ГЭТ-18 ✓ УАТ-16 ЭМЧ, сувилагч		2	ХСХ-ын ерөнхий ойлголт Гарын эрүүл ахуй сахих	✓ ЯТТ-21 ✓ ДОТ-11 ✓ VIP-12 ✓ ЕМЗТ-1,2 ЭМЧ, сувилагч		3	ЭТҮХХ-ын ерөнхий ойлголт	✓ ЦЭСЧШСТ-18 ✓ ЕМЗТ-23 ЭМЧ, сувилагч		5	ЭМС-ын А/537 тоот тушаалын зургаадугаар хавсралтын дагуу Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх заавар болон ерөнхий зарчим	Мэс заслын болон дотрын тасгийн 36 үйлчлэгч		6	HIV-н халдвараас сэргийлэх, тусламж үйлчилгээний менежмент ЭТҮХХ-ын тандалт, сэжигтэй тохиолдол	Нийт 150 эмч нар	
№	Сургалтын сэдвүүд	Хамрагдсан тасаг, хүний тоо	Сургалтын он сар, тайланг тус бүр бичин гарын үсгээр баталгаажуулж тасагт хүргүүлэв.																													
Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус																																
1	Судасны холбоотой халдвар ЭТҮХХ-ын халдварын тандалт	✓ VIP- 12 ✓ ГЭТ-18 ✓ УАТ-16 ЭМЧ, сувилагч																														
2	ХСХ-ын ерөнхий ойлголт Гарын эрүүл ахуй сахих	✓ ЯТТ-21 ✓ ДОТ-11 ✓ VIP-12 ✓ ЕМЗТ-1,2 ЭМЧ, сувилагч																														
3	ЭТҮХХ-ын ерөнхий ойлголт	✓ ЦЭСЧШСТ-18 ✓ ЕМЗТ-23 ЭМЧ, сувилагч																														
5	ЭМС-ын А/537 тоот тушаалын зургаадугаар хавсралтын дагуу Эрүүл мэндийн байгууллагад цэвэрлэгээ хийх заавар болон ерөнхий зарчим	Мэс заслын болон дотрын тасгийн 36 үйлчлэгч																														
6	HIV-н халдвараас сэргийлэх, тусламж үйлчилгээний менежмент ЭТҮХХ-ын тандалт, сэжигтэй тохиолдол	Нийт 150 эмч нар																														
7.2	Бичил биетний тэсвэржилтийг тандах	7.2.1 Эмэнд тэсвэртэй биегний тандалтын нэгдсэн бичил тандалтын	Лавлагаа болон төрөлжсөн мэргэжлийн эмнэлгийн нян	ЭТҮХХ, Олон эмэнд тэсвэржсэн бичил биетэн (ОЭТББ) -ийн халдварын батлагдсан тохиолдлыг халдварын сэргийлэлт албанд лабораториос 72 цагийн дотор мэдээллэж ажилдаг																												

	тогтолцоог сайжруулах, тэсвэртэй бичил биетний тархалтыг хянах	тогтолцоог бүрдүүлэх	судлалын лабораторт тэсвэртэй бичил эмэнд	хяналтын тогтолцоотой бөгөөд 2 төрлийн зураглалыг боловсруулан тасгуудад тандалт судалгааг хийдэг.
	7.2.3 Эрүүл мэндийн байгууллагад тэсвэртэй бичил биетний халдааразс сэргийлэх үйл	Тэсвэртэй халдвартай үйлчлүүлэгчийг илрүүлэх тандалт эхэлсэн Бичил тэсвэржилтийн	нянгийн идэвхитэй хийж байна. биетний дүн	Жил бүрийн 11-р сарын Эрүүл мэндийн яам, Улсын Нэгдүгээр төв эмнэлэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, ДЭМБ хамтран “Бичил биетний тэсвэржилтийн талаарх мэдлэг, хандлагыг дээшлүүлэх” аяныг “Мэдлэг олгоё. Нөлөөлье. Яг одоо” уриатайгаар зохион байгуулж байгаа бөгөөд аяны хүрээнд эмийн хог хаягдалыг цуглуулан байгальд ээлтэйгээр утсгууллаа. Мөн “Бичил биетний тэсвэржилтээс хамтдаа сэргийлье” сэдэвт танхимын

		ажиллагааг эрчимжүүлэх	мэдээнд амтмбиограмыг болоесруулж эсрэг эмчилгээнд ашигладаг байна.	үндэслэн нянгийн эмийн болсон	болон онлайн хосолсон 1 багц цагийн сургалтыг зохион байгууллаа.  Зураг 1. Үйл ажиллагааны явцаас  Зураг 2. Сургалтын явцаас Тайлант хугацаанд ХСХА нь ЭМС-ын А/538, А/539 тоот тушаалд заасны дагуу ЭТҮХХ болон олон эмэнд тэсвэртэй нянгийн илрүүлэг, халдварын тохиолдлын халдвар илрүүлэх
--	--	-------------------------------	--	--------------------------------------	---

			тандалтын зааварчилгааг бүхий самбарыг хийж төв тасгуудийн хананд байршуулж үйл ажиллагаандаа ашиглаж байна. УНТЭ-т УНТЭ-т 2024 оны 01.01-10.31-ны хооронд Олон эмэнд тэсвэртэй нянгийн 1535 тохиолдол бүртгэгдсэнээс: ✓ Амбулаторит 440 ✓ Яаралтай тусламжийн тасагт-203 ✓ Стационарт 892 тохиолдлыг илрүүлсэн. Хэвтэн эмчлүүлэх тасагт илэрсэн 892 тохиолдолд тандалт судалгаа хийн УНТЭ-с шалтгаалсан олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвар байж болзошгүй 36 тохиолдлыг сэжигтэй тохиолдлоор бүртгэсэн. ОЭТН-н сэрэмжлүүлэх нянгийн халдварыг үүсгэгчээр нь задлан авч үзвэл: MRSA, ESBL E-Coli, Acinetobacter baumannii, ESBL Klebsiella pneumoniae халдвар давамгайлсан тохиолдож байна ОЭТН-ын давамгайлсан илэрч байгаа үүсгэгч %-р <table><tr><th>Үүсгэгч</th><th>2023 (n=1300)</th><th>2024 (n=1535)</th></tr><tr><td>Acinetobacter baumannii complex</td><td>37%</td><td>40%</td></tr><tr><td>MRSA</td><td>9%</td><td>5%</td></tr><tr><td>ESBL E.coli</td><td>52%</td><td>45%</td></tr><tr><td>ESBL E.coli</td><td>2%</td><td>10%</td></tr></table> ОЭТН-н сэрэмжлүүлэх нянгийн халдварыг сорьцны төрлөөр нь задлан авч үзвэл: • ESBL- E.coli -ийн илрэлт нь 612 Нийт илэрсэн сорьцын 63,% нь шээсэнд, 11% нь идээ, 3% хэвлийн шингэнд тус тус илэрч байна.	Үүсгэгч	2023 (n=1300)	2024 (n=1535)	Acinetobacter baumannii complex	37%	40%	MRSA	9%	5%	ESBL E.coli	52%	45%	ESBL E.coli	2%	10%
Үүсгэгч	2023 (n=1300)	2024 (n=1535)																
Acinetobacter baumannii complex	37%	40%																
MRSA	9%	5%																
ESBL E.coli	52%	45%																
ESBL E.coli	2%	10%																

- MRSA -ийн илрэлт нь 622 Нийт илэрсэн сорьцын 38% нь шарх, 48% нь идээний арчсанд тус тус илэрч байна.
- Acinetobacter baumannii -ийн илрэлт нь 64 Нийт илэрсэн сорьцын 40% нь цэр, 11% нь цус 14% шархны арчсанд тус тус илэрч байна. Үүнд:



АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ 1-Р АРГА ХЭМЖЭЭ: ТУСГААРЛАН СЭРГИЙЛЭЛТ

Дээрх тушаалуудын дагуу ОЭТН-тай үйлчлүүлэгчийг ОУ-н стандартын дагуу тусгаарлах өрөөг хангалтгүй бөгөөд тасаг тус бүр тусгаарлах өрөөг гарган, бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. Мөн ОЭТН-тай нянтай үйлчлүүлэгчийн орны дэргэд тусгай таних тэмдэг байршуулан тасаг дотроо халдвар

хамгааллын дараах стандарт сэргийлэлтийн арга хэмжээг
хэрэгжүүлэн ажилласан



АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ 2-Р АРГА ХЭМЖЭЭ: ОЭТН-Н ТАНДАЛТ, СУДАЛГАА

Тайлант хугацаанд лабораториос 72 цагийн дотор ирсэн олон эмэнд тэсвэртэй нянгийн мэдээллийн дагуу хэвтэн эмчлүүлэх тасгийн нийт 892 тохиолдолд өвчний түүх болон бактерлоги шинжилгээний хариуг үндэслэн тархвар судлалын нарийвчилсан тандалт судалгааг хийсэн байна.

[illegible]

АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ 3-Р АРГА ХЭМЖЭЭ: ЦЭВЭРЛЭГЭЭ, ХАЛДВАРГУЙТГЭЛ

Тайлант хугацаанд Солонгос улсын АНСАН эмнэлгийн халдварын сэргийлэлт, хяналтын төвийн туршлагыг нэвтрүүлсний дагуу төв, тасгуудад халдвартай үйлчлүүлэгч хэвтсэн тохиолдолд тусдаа үйлчлэгч тухайн өрөөг өндөр зэргийн халдваргүйжүүлэх бодис ашиглан цэвэрлэгээ, үйлчилгээ хийж байгаа бөгөөд 2024 оны байдлаар станционарт хэвтэн эмчлүүлсэн ОЭТН-н 892 тохиолдлуудад өдөр бүр цэвэрлэгээ халдваргүйтгэлийн дуудлага болон хуваарийн дагуу хийн гарын үсэг бүртгэл ахлах сувилагчийн үнэлгээгээр баталгаажуулан ажилласан байна.

[illegible]

				АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ 4-Р АРГА ХЭМЖЭЭ: СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ Тайлант хугацаанд тандалт судалгааны дүгнэлт дээр үндэслэн тасгийн нийт эмч ажилтануудад давамгайлан илэрч байгаа үүсгэгчүүд болон ЭТҮХХ-н талаар нийт 892 эмч, ажилчдад 7 чиглэлээр 14 удаагийн сургалтуудыг тогтмол зохион байгуулж сургалтын өмнө болон дараа тестийн шалгалтыг авч , гарсан үл тохирол% эрсдлийн асуулт хариулт хэлбэрээр ярилцан, сэргийлэх арга хэмжээ, заавар, зөвөлгөөг өгөн ажилласан байна   
--	--	--	--	--

Хянасан: ХСХА-ны дарга

Тайлан бичсэн: ХСХА-ны халдвар судлаач эмч



Б.Намуун

Н.Булган


УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН БОЛОН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024
ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр /сая төг/		
Зорилго. Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүчирхийлэлд өртсөн хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах						
Зорилт 2. Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллийн нөлөөллийн талаарх тандалт судалгаа,статистик бүртгэлийг боловсронгуй болгож, нэгдсэн мэдээллийн сан байгуулах						
1.	2.1 Ажлын байран дээрх жендэрт суурилсан хүчирхийллийг судлах	Эрүүгийн хуулиас ажлын байран дээрх бэлгийн дарамт үзүүлсэн тохиолдолд ял хүлээлгэх тухай зүйл заалтыг хассан нь салбар дахь АББД-ын нөхцөл байдлыг судлана.	-	-	1. Эмнэлгийн ерөнхий захирлын 2022.07.28-ны А/246 тоот тушаалаар "Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журам"-ыг баталж мөрдөн ажиллаж байна. Уг журамд нэр томъёоны тодорхойлолт, ойлголт, ажил олгогч, ажилтны эрх үүрэг, хориглох зүйл, гомдол мэдээллийг шийдвэрлэх, хянан шалгах ажиллагаа, гомдол мэдээлэл гаргах процессын зураглал, асуулгуудыг нарийвчлан тусгасан.	

					2. Эмнэлгийн ерөнхий захирлын 2022.07.28-ны А/246 тоот тушаалаар "Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журам"-ыг баталж мөрдөн ажиллаж байна. Уг журамд нэр томъёоны тодорхойлолт, ойлголт, ажил олгогч, ажилтны эрх үүрэг, хориглох зүйл, гомдол мэдээллийг шийдвэрлэх, хянан шалгах ажиллагаа, гомдол мэдээлэл гаргах процессын зураглал, асуулгуудыг нарийвчлан тусгасан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	--

Зорилт 4. Жендэрт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, олон нийтэд зориулсан сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах

4.10 Хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аянд нэгдэх, олон нийтийн мэдээллийн сүлжээтэй хамтран ажиллах	12 үйл ажиллагаа явуулна			Жэндэрт суурьлсан хүчирхийллэлтэй тэнцэх 16 хоногийн аяныг Дэлхийн 180 гаруй улс жил бүрийн 11 сарын 25-наас 12 сарын 10”ны өдөө нэгдмэл зорилгоор нэг уриан дор тэмдэглэн өнгөрүүлдэг билээ. Энэ жилийн хувьд Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж Анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойг улс орон даяар тэмдлэглэн өнгөрүүлэх үйл ажилалаагатай тус аяны нээлт давхцаж байгаа тул тус аяныг 2024 оны 11 сарыг 22-ны өдөр “Шалтаг бүү тооч- Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй” уриан дор зохион байгуулагдаж байна  Зураг 2. Үйл ажиллагааны явцаас	
---	--------------------------	--	--	---	--

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН


Д/Д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр /сая төг/		
Зорилго: Хөтөлбөрийн зорилго нь хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, нийгэм хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл тусламж, үйлчилгээг өргөжүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хянах, бэхжүүлэх, хүн амд эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд оршино.						
Зорилт 1.Сэтгэцийн эрүүл мэндийн хууль эрхзүйн орчин, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах						
1.	1.9 Албан ажлын сэтгэлзүйн хэм хэмжээг байгууллагын дотоод дүрэм, журам, хамтын гэрээнд тусган мөрдөж ажиллах, хамт олныхоо сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах	Ажлын байранд сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн төлөвлөгөөг баталж, 50 байгууллагад хэрэгжүүлсэн байна.	-	-	1. 2024 онд сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээг нийт 312 хүн/давхардсан тоогоор/ үзүүлсэн байна. Үүнээс тасгаас - 97 Ажилтан, түүний гэр бүл – 132 Төлбөртэй -83 Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын тусламжинд ➢ "Хүн байшин мод" одоогийн сэтгэийн байдал, сэтгэл зүйн гэмтлийн илрүүлэх зургийн сорил Проектив сэтгэл заслын зурган картууд ➢ 1.Персона /Хувь хүний сэтгэл зүйн байдал, тулгамдаж буй асуудал,	

					харилцааны зөрчлийг илрүүлэх, сэтгэл засах/ ➤ Персонита / Хувь хүний сэтгэл зүйн байдал, бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ ➤ Инук / Бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ ➤ Oh card/ Хувь хүний сэтгэл зүйн байдал, бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ ➤ Амьдрахын тулд уучил /Уй гашуутай ажиллах, сэтгэл засах/ ➤ EQ- /хүүхдийн сэтгэл хөдлөлтэй ажиллах/ картуудыг ашиглаж байна. 2. 2024 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан үйл ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөндөө ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор “Шинэ сувилагч” арга хэмжээний хүрээнд “Ажлын байранд дасан зохицохуй” “Стресс менежмент” сэдвээр 3 удаа, Зүрх судасны тасаг болон Ариутгал халваргүйтгэлийн тасгийн хамт олонд “Ажлын байран дээрхи эерэг уур амьсгал” сэдвээр проектив зурган картын аргаар бүлгийн сэтгэл засал эмчилгээг 2 удаа, нийт ажилчдад “Сэтгэцийн эрүүл мэнд ба сэтгэл зүйн сайн сайхан байдал” “Стресс	
--	--	--	--	--	--	--

ба таргалалт” сэдвээр 2 удаа тус тус зохион байгуулсан. Мөн өөрөөс гаралтай тайвшруулах сэтгэл засал болон урлагийн сэтгэл заслын эмчилгээний аргууд болох чиглүүлэгт зурган засал, элсэн заслын аргуудыг нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.



Зураг 1. Байгууллагын хамт олны групп дээр сэтгэл заслын аргуудаа танилцуулж мэдээлж буй явцаас



Зураг 2. Сургалтын явцаас

Зорилт 2. Сэтгэцийг эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх, нийгэм, хамт олонд, түшиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах

2.	2.17. Сэтгэцийн эрүүл мэнд болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээллийг хүүхэд өсвөр үеийн онцлог хэрэгцээнд нь тохирсон байдлаар хүргэх, тэдний идэвхитэй ашигладаг мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх ажлыг зохион байгуулах	Хүүхэд бүрийн сонирхол, онцлог хэрэгцээнд нь тулгуурлан сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цахим хуудас,инстаграм, фэйсбүүкийг тогтмол ашигладаг болсон байна.	-	-	1. УНТЭ-ийн НЭМА-ны сэтгэц, сэтгэл заслын эмч А.Оюунжаргал “Бидний мэдрэмж” ТББ-тай хамтран хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэнд тэр дундаа сэтгэцийн эрүүл мэндийн талаарх цуврал медиа контентуудыг хамтран хийж цахим орчинд байршуулан түгээн ажилладаг. Хүн амын дунд түгээмэл ашигладаг цахим плапформ болох фэйсбүүк фэйж хуудас “Medic” хуудсыг ТББ-ын мэргэжилтнүүдтэй хамтран хөтлөн явуулдаг бөгөөд уг цахим хуудас нь хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, цахим зөвлөгөө мэдээллийг нийтэд түгээх зорилготой. 2024 онд сэтгэцийн эрүүл мэнд болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийн дагуу “Хүүхэд насны сэтгэл зүйн гэмтэл”, “Сэтгэл гутрал”, “Хүүхэд, өсвөр насныхны сэтгэцийн эрүүл мэндийн өнөөгийн байдал”, “Хүүхэд яагаад уйлдаг вэ?” “Аав намайг сонсоосой” “ Хичээлийн шинэ жилд хүүхдээ хэрхэн бэлдэх вэ” “ Үе тэнгийн дээрэлхэлт””Өсвөр насныханы дундах амиа хорлолт” “Хүүхдийн хэт хөдөлгөөнтөх импульсив эмгэг гэж юу вэ” зэрэг цахим контентуудыг бэлтгэн хүргэсэн бөгөөд нийт хандалтын тоо 4000-6000 үзэлттэй байна.	
----	--	--	---	---	--	--


					Зураг 3. Medic фэйсбүүк фэйж хуудас дээр мэдээлэл байршуулсан явцаас 2. Өсвөр үе залуучуудын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох ажлын хүрээнд СЭЗИС-ийн 60 гаруй багш ажилтнуудад “Өсвөр үеийн сэтгэл зүйн байдал”, "Сэтгэл зүйн сайн сайхан байдал стресс менежмент" сэдвүүдээр танхимын сургалт зохион байгуулсан	
--	--	--	--	--	---	--

					бөгөөд цаашид уг сургалтыг өргөжүүлж танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөж байна.  Зураг 4. Сургалтын явцаас		
Зорилт 3. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж өргөжүүлэх							
3.	3.29. Ахмад настны сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх, хүртээмжийг сайжруулах ажлыг зохион байгуулах	ЭМС-ын А/517 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч эмнэлгийн мэрэгжилтнийг	-	-	УНТЭ нь ахмад настны сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих урьдчилан сэргийлэх чиглэлээр УНТЭ-ийн Ахмадын зөвлөлтэй хамтран ахмад ажилтнуудынхаа эрүүл мэндийг дэмжих зорилгоор урьдчилан сэргийлэх үзлэгийг 2024. 05.09-ний өдөр УНТЭ-ийн Эрүүл мэндийг дэмжих төв дээр зохион байгуулсан бөгөөд үзлэгт зөвлөлийн 15 гаруй ахмад		

		сургаж ур чадварыг сайжруулсан байна.			ажилтан хамрагдсан ба цаашид төлөвлөгөөний дагуу ахмад ажилтнууд хамрагдахаар бэлтгэл ажлаа хангаж байна. Уг урьдчилан сэргийлэх үзлэгээр ахмадуудын сэтгэцийн эрүүл мэнд тэр дундаа нойргүйдэл, сэтгэл хямрал, сэтгэл түгшилт зэргийг илүүтэйгээр оношлон тогтоож сэтгэл заслын эмчилгээний аргуудаар оношлон эмчилгээ үйлчилгээг үзүүлэн ажилласан бөгөөд цаашид байнгын хяналтанд хамруулахаар төлөвлөж байна. Мөн улс орон даяар зохион байгуулагдаж буй “Хүн амын нас, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ”-нд хамрагдаж буй 60-с дээш насны ахмадуудад сэтгэцийн эрүүл мэндийн эрсдлийн асуумжийг авч асуумжинд үндэслэн тусламж үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмнэлэгт холбон зуучилж, харьяа дүүрэг хорооны өрхийн хяналтанд бүртгэлжүүлэн ажиллаж байна. 	
--	--	---------------------------------------	--	--	---	--

Зураг 5. Үзлэгийн явцаас

Ахмад настны сэтгэл зүйн асуудлаар АШУҮИС-ын багш, доктор О.Саранчулуунтай хамтран “Ахмад настны хийгмийн харилцаа ба сэтгэл зүй” сэдвээр онлайн сургалт зохион байгуулсан.



Зураг 6. Сургалтын явцаас

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр /сая төг/		
Дөрөв. Хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлэх						
1.	4.32. Бага насны хүүхэдтэй ажилтныг дэмжих, ажлын цагийн болон “Хүүхэд асрах чөлөө”-ний уян хатан зохицуулалтыг хэрэгжүүлэх, эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх	Эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан арга хэмжээ, нөлөөллийн ажлын тоо	-	-	1. Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг нь ЭМС-ын 2023.07.03-ны өдрийн А/240 тоот тушаалын хэрэгжилтийг хангах чиглэлээр 2023.09.04-ны өдөр Ерөнхий захирлын А/233 тоот тушаалаар “Эцэг эхийн зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам”-ыг батлуулсан бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 онд ахлах ангийн сурагчдын дунд “Аав ээжийнхээ ажлын онцлог, бодит байдлыг илүү ойлгох, цаашид мэргэжил сонголтонд туслах” сэдэвт эцэг эхийнхээ ажлын нэг өдөртэй танилцах өдөрлөгийг 2024.04.16-ны өдөр	

					зохион байгуулсан бөгөөд өдөрлөгт ЕБС-ийн 12 ангийн 15 гаруй хүүхэд оролцсон бөгөөд өдөрлөгөөр “Харах өнцөг өөрчлөгдвөл хандлага өөрчлөгдөнө” сэдвээр хүндэтгэлийн лекц, “Цахилгаан тамхины хор уршиг” сэдвээр сургалт мэдээлэл олгосон бөгөөд өдөрлөгийн гол зорилго нь ахлах ангийн сурагчдад аав, ээжийнх нь ажлын байрны онцлогийг танилцуулах, цаашлаад мэргэжил сонголт хийхэд нь туслах юм. Өдөрлөгийн үеэр сурагчид таван өртөөгөөр зочлон эмнэлгийн үйл ажиллагаатай биечлэн танилцахаас гадна гарын эрүүл ахуй сахиx дадалд суралцах, амилуулах суурь тусламж үзүүлэх анхан шатны мэдлэг олгосон.  Зураг 1. Зөвлөлийн тушаал	
--	--	--	--	--	--	--



Зураг 2. Өдөрлөгийн явцаас

2. УНТЭ-ийн Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 10.11.3 дахь заалтын дагуу Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид элсэн орж байгаа хүүхэдтэй ажилтанд нотлох баримтыг үндэслэн хичээлийн жилийн хугацаанд ажил эхлэх эсвэл ажил дуусах цагаас 1 цагаар богиносгож хөнгөлөлт

					үзүүлж ажиллаж байна. 2024 оны байдлаар ЕБС-ын 1-р ангид хүүхэд нь элсэн суралцаж буй ажилтанд 1 цагийн богисносон цагаар ажиллаж буй 25 ажилтан байгаа бол Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 10.12.3 дахь заалтын дагуу эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй ажилтаны ажлын цагийг 1 цагаар богиносгон ажиллуулж буй 13 ажилтан байна. Мөн байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 12.10.4 дэх заалтын дагуу ажилтны төрсөн аав, ээж, эхнэр (нөхөр), үр хүүхэд зэрэг гэр бүлийн аль нэг гишүүнд шаардлагатай тохиолдол бүрт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна.	
--	--	--	--	--	---	--

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО, 2021-2024 ОНД БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2024 оны хүрэх түвшин	Төсөв		Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь
			Нийт төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв эх үүсвэр /сая төг/		
Зорилго: Эрүүл мэндийн салбарын бүх түвшинд ажиллагсдын жендерийн боловсролыг дээшлүүлж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээ , нөхцөл байдлыг тооцсон, үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй жендерийн мэдрэмжтэй бодлого,бүтэц, үйлчилгээний орчин бүрдүүлж хөгжүүлэх						
Зорилт 1. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын эмч, эмнэлгийн ажиллагчдын ажиллах орчин болон иргэдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш боломж, чанар, хүртээмжийг сайжруулах						
1.	1.21.Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд эрэгтэйчүүдийн кабинетийн (урологи андрологи) тусламж үйлчилгээг үзүүлдэг болсон байх	Уролои андрологийн тусламж үйлчилгээг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд үзүүлдэг болсон байна.	-	-	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 13-р зүйлийн 13.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2020 оны 07 сарын 01-ний өдрийн дугаар 99-р захирамжаар батлагдсан “Эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.3 дахь заалтын хүрээнд төрөөс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээ бий болгох зорилгын дор УНТЭ-ийн Урологи Андрологийн төв нь ‘Эрэгтэйчүүдийн кабинетын үлгэрчилсэн загвар, ажиллах журам батлах тухай тушаалыг	

					боловсруулсан бөгөөд уг журмыг ЭМС-ын 2022 оын 09 сарын 05 өдрийн А/449 тоот тушаалаар батлуулсан бөгөөд уг журмын дагуу эрэгтэйчүүдэд андрологийн тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.	
2.	1.32.Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал, өвчлөл, нас баралтын зан үйлийн, нийгмийн хүчин зүйлийн шалтгааныг судлах	Судалгааны эхний үр дүн гарч танилцуулагдсан байна.	-	-	1. ЭМЯ-наас 2024.03.20-ны өдөр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдсэн “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн хэрэгцээ, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжтэй холбоотой саад, бэрхшээлийг тодорхойлсон хэвлэлийн тойм судалгаа”-г танилцуулах уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд УНТЭ-с УАТ-ын эмч П.Мягмарсүрэн, НЭМА-ны мэргэжилтэн О.Чанцалдулам нар оролцож эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал, дундаж наслалтын зөрүүг арилгах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн талаар санал бодлоо солилцсон. 2. Жэндэрийн үндэсний хорооноос 2024.10.22-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулах уулзалт зохион байгуулсан бөгөөд УНТУ-с НЭМА- дарга Г.Алтанцоо оролцож эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал,	

					дундаж наслалтын зөрүүг арилгах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийн талаар санал бодлоо хүргүүллээ. 3. УНТЭ-ийн УАТ-ийн эмч П.Мягмарсүрэн нь Жендерийн үндэсний хорооны сургагч багш бөгөөд 2024.05.14-ны өдөр Жендерийн үндэсний хорооноос бэлтгэн хүргэж буй “Хуваалцъя” ярилцлага нэвтрүүлэгт оролцож “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал” сэдвээр ярилцаж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. 3. УНТЭ-ийн УАТ-ийн эмч П.Мягмарсүрэн нь Жендерийн үндэсний хорооны сургагч багш бөгөөд 2024.05.14-ны өдөр Жендерийн үндэсний хорооноос бэлтгэн хүргэж буй “Хуваалцъя” ярилцлага нэвтрүүлэгт оролцож “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал” сэдвээр ярилцаж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. 4. Жэндэрт суурьлсан хүчирхийллэлтэй тэнцэх 16 хоногийн аяныг Дэлхийн 180 гаруй улс жил бүрийн 11 сарын 25-наас 12 сарын 10”ны өдөө нэгдмэл зорилгоор нэг уриан дор тэмдэглэн өнгөрүүлдэг билээ. Энэ жилийн хувьд Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж Анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойг улс орон даяар тэмдэглэн
--	--	--	--	--	--

				өнгөрүүлэх үйл ажиллалаагатай тус аяны нээлт давхцаж байгаа тул тус аяныг 2024 оны 11 сарыг 22-ны өдөр “Шалтаг бүү тооч- Охид эмэгтэйчүүд хаана ч аюулгүй” уриан дор зохион байгуулагдаж байна 	
--	--	--	--	---	--

Зураг 2. Үйл ажиллагааны явцаас

Хянасан: Нийгмийн эрүүл мэндийн албаны дарга

Тайлан бичсэн : Нийгмийн эрүүл мэндийн албаны мэргэжилтэн

Нийгмийн эрүүл мэндийн албаны сэтгэгч, сэтгэл заслын их эмч

Нийгмийн эрүүл мэндийн албаны хоолзүйч

Г.Алтанцоо

Д.Гандулам

А.Оюунжаргал

Э.Санчир